

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЖАРГАЛАНТ СУМЫН 6 ДУГААР СУРГУУЛИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/07/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh
@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг:
Tsetsegsuren.A@audit.gov.mn

Гэрэлт Хөхийн тэнцвэр Аудит ХХК –ны

Ховд дахь салбар

Аудитор: Д.Хишгээ

Утас: 99964238 Цахим хаяг: Hishgee.Da@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	10
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	15
Аудитын зөвлөмж	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	15
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

1.Төрийн аудитын санал, дүгнэлт


**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
B4000 Цамбагараа баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

**ЖАРГАЛАНТ СУМЫН 6 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.БАРСБОЛД ТАНАА**

АДА.02.09 № 2/40
талай _____ -ны № _____ -Т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт
Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.
Аудитаар Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.
Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага
Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.
Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БАРСБОЛД


001020015

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>92,053,832.75</u>	<u>162,806,053.21</u>
33	АВЛАГА	219,984.94	13,663.08
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	219,984.94	13,663.08
35	БАРАА МАТЕРИАЛ	91,833,847.81	162,792,390.13
351	Түүхий эд материал	-	4,315,300.00
35130	Эм боох материал	-	4,315,300.00
354	Хангамжийн материал	91,833,847.81	158,477,090.13
35410	Бичиг хэргийн материал	2,032,250.00	2,032,250.00
35420	Аж ахуйн материал	2,741,277.00	2,741,277.00
35470	Бусад хангамжийн материал	87,060,320.81	153,703,563.13
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,954,769,863.64</u>	<u>2,039,477,779.46</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,954,769,863.64	2,039,477,779.46
392	Биет хөрөнгө	1,648,652,113.60	1,733,474,279.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,598,146,882.34	1,722,942,059.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	(76,913,331.36)	(163,391,580.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	230,864,019.63	252,597,815.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(210,313,426.65)	(222,668,883.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	120,962,147.66	164,703,226.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	(79,716,417.57)	(91,711,238.49)
39217	Ном	65,622,239.55	71,002,880.21
393	Биет бус хөрөнгө	306,117,750.04	306,003,500.08
39301	Програм хангамж	857,000.00	857,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(514,249.96)	(628,499.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	305,775,000.00	305,775,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,046,823,696.39</u>	<u>2,202,283,832.67</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>41,860.82</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	41,860.82
413	Өглөг	-	41,860.82
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	41,860.82
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,046,823,696.39</u>	<u>2,202,241,971.85</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,046,823,696.39	2,202,241,971.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нуггийн сан	1,788,204,349.14	1,788,204,349.14
51101	Өмч: - төрийн	1,788,204,349.14	1,788,204,349.14
512	Хуримтлагдсан үр дүн	(529,829,948.70)	(374,411,673.24)
51210	Өмнөх үеийн үр дүн	(529,829,948.70)	(529,829,948.70)
51220	Тайлант үеийн үр дүн	-	155,418,275.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	788,449,295.95	788,449,295.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,046,823,696.39</u>	<u>2,202,283,832.67</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,691,491,257.00	2,103,080,434.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,234,024.00	117,970,757.85
120	Нийтлэг татварын бус орлого	34,010,893.00	2,987,194.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,553,297.00	-
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	713,617.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,839,680.00	-
120005	Түрээсийн орлого	17,457,596.00	2,987,194.50

122	Тусламжийн орлого	19,223,131.00	114,983,563.35
122001	Хандив тусламж /дотоод/	19,223,131.00	114,983,563.35
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,638,257,233.00	1,985,109,677.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,380,513,600.00	1,591,594,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,293,884,700.00	1,591,594,400.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	86,628,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,384,200.00	360,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,564,200.00	360,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	820,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	238,232,117.00	393,155,277.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	237,518,500.00	268,360,100.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	713,617.00	-
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	124,795,177.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	127,316.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	127,316.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,649,349,874.03	1,947,662,159.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,649,349,874.03	1,947,662,159.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,595,623,358.03	1,873,981,355.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,092,838,013.00	1,343,551,431.00
210101	Үндсэн цалин	804,806,969.00	876,538,284.00
210102	Нэмэгдэл	214,087,019.00	354,232,706.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	18,928,000.00
210104	Урамшуулал	73,944,025.00	93,852,441.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,675,065.34	167,829,404.42
210201	Тэтгэврийн даатгал	93,165,989.46	114,626,627.48
210202	Тэтгэмжийн даатгал	10,960,704.64	13,483,790.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,758,323.71	10,780,312.13
210204	Ажилгүйдлийн даатгал	2,162,731.59	2,625,797.82
210205	Эрүүл мэндийн даатгал	21,627,315.94	26,312,876.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235,824,004.00	234,013,343.38
210301	Гэрэл, цахилгаан	6,976,070.00	4,058,351.60
210302	Түлш, халаалт	204,687,734.00	198,374,191.78
210303	Цэвэр, бохир ус	24,160,200.00	31,580,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,135,004.49	4,012,900.00
210401	Бичиг хэрэг	2,652,980.00	794,600.00
210402	Тээвэр, шатахуун	52,500.00	55,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,040,488.00	1,051,000.00
210404	Ном, хэвлэл	116,500.00	49,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	486,100.00	630,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	511,466.00	1,433,300.00
210408	Бараа материал акталсны зардал	8,274,970.49	-
2105	Нормативт зардал	2,411,570.00	4,976,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	248,400.00	3,312,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,163,170.00	1,663,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,856,830.00	3,726,900.00
210604	Урсгал засвар	2,856,830.00	3,726,900.00
2107	Томилолт, зочны зардал	330,000.00	160,000.00
210702	Дотоод албан томилолт	330,000.00	160,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	982,804.00	767,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	982,804.00	767,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,570,067.20	114,943,626.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,122,600.00	326,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,095,447.00	3,674,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,352,020.20	110,942,776.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,726,516.00	73,680,803.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,726,516.00	29,247,200.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	127,316.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,599,200.00	29,247,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	44,433,603.88
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	44,433,603.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	42,141,382.97	155,418,275.46
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	42,141,382.97	155,418,275.46

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,641,660,076.00</u>	<u>1,862,246,318.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,402,843.00	1,931,818.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,402,843.00	1,931,818.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	713,617.00	-
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	713,617.00	-
120005	Түрээсийн орлого	2,689,226.00	1,931,818.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,638,257,233.00	1,860,314,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,380,513,600.00	1,591,594,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,293,884,700.00	1,591,594,400.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	86,628,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,384,200.00	360,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,564,200.00	360,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	820,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	238,232,117.00	268,360,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	237,518,500.00	268,360,100.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	713,617.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	127,316.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	127,316.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,554,317,559.00</u>	<u>1,862,246,318.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,554,317,559.00	1,862,246,318.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,500,591,043.00	1,789,365,514.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,092,199,800.00	1,345,847,294.74
210101	Үндсэн цалин	767,921,687.00	845,731,300.00
210102	Нэмэгдэл	244,540,346.00	383,481,489.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	19,622,294.74
210104	Урамшуулал	79,737,767.00	97,012,210.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,837,500.00	165,285,358.00
210201	Тэтгэврийн даатгал	92,369,400.00	115,526,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,867,000.00	12,439,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,693,600.00	9,951,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,173,400.00	2,487,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,734,100.00	24,880,958.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235,824,004.00	248,929,343.38

210301	Гэрэл, цахилгаан	5,718,200.00	4,058,351.60
210302	Түлш, халаалт	203,708,704.00	213,290,191.78
210303	Цэвэр, бохир ус	26,397,100.00	31,580,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,866,004.00	4,953,400.00
210401	Бичиг хэрэг	863,650.00	857,600.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,289,954.00	1,281,900.00
210404	Ном, хэвлэл	805,500.00	807,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	438,600.00	438,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,368,300.00	1,368,300.00
2105	Нормативт зардал	2,087,200.00	9,915,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	385,900.00	7,451,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,701,300.00	2,463,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,726,900.00	3,726,900.00
210604	Урсгал засвар	1,726,900.00	3,726,900.00
2107	Томилот, зочны зардал	330,000.00	160,000.00
210702	Дотоод албан томилот	330,000.00	160,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.00	767,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	767,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,711,635.00	9,781,168.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,427,000.00	600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,284,635.00	9,181,168.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,726,516.00	72,880,803.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,726,516.00	28,447,200.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	127,316.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,599,200.00	28,447,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	44,433,603.88
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	44,433,603.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>87,342,517.00</u>	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	87,342,517.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,788,204,349.14	788,449,295.95	(484,628,814.67)	2,092,024,830.42
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,788,204,349.14	788,449,295.95	(484,628,814.67)	2,092,024,830.42
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(45,201,134.03)	(45,201,134.03)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,788,204,349.14	788,449,295.95	(529,829,948.70)	2,046,823,696.39
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,788,204,349.14	788,449,295.95	(529,829,948.70)	2,046,823,696.39
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,788,204,349.14	788,449,295.95	(529,829,948.70)	2,046,823,696.39
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	155,418,275.46	155,418,275.46
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,788,204,349.14	788,449,295.95	(374,411,673.24)	2,202,241,971.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,860,554,500.00	1,816,120,896.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,860,554,500.00	1,816,120,896.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,817,549,800.00	1,787,673,696.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,343,424,200.00	1,345,847,294.74
210101	Үндсэн цалин	845,731,300.00	845,731,300.00
210102	Нэмэгдэл	391,691,900.00	383,481,489.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,199,200.00	19,622,294.74
210104	Урамшуулал	88,801,800.00	97,012,210.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,362,200.00	165,285,358.00
210201	Тэтгэврийн даатгал	127,625,300.00	115,526,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,434,300.00	12,439,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,747,400.00	9,951,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,686,800.00	2,487,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,868,400.00	24,880,958.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	264,633,200.00	248,929,343.38
210301	Гэрэл, цахилгаан	6,633,000.00	4,058,351.60
210302	Түлш, халаалт	226,419,400.00	213,290,191.78
210303	Цэвэр, бохир ус	31,580,800.00	31,580,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,972,900.00	4,953,400.00
210401	Бичиг хэрэг	877,100.00	857,600.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,281,900.00	1,281,900.00
210404	Ном, хэвлэл	807,000.00	807,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	438,600.00	438,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,368,300.00	1,368,300.00
2105	Нормативт зардал	9,952,700.00	9,915,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,451,100.00	7,491,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,501,600.00	2,423,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,726,900.00	3,726,900.00
210604	Урсгал засвар	3,726,900.00	3,726,900.00
2107	Томилолт, зочны зардал	614,000.00	160,000.00
210702	Дотоод албан томилолт	614,000.00	160,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	767,000.00	767,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	767,000.00	767,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,096,700.00	8,089,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,496,700.00	7,489,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,004,700.00	28,447,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,004,700.00	28,447,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,004,700.00	28,447,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,619,030,500.00	1,816,120,896.12
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,591,594,400.00	1,547,160,796.12
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,591,594,400.00	1,547,160,796.12
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,836,100.00	268,360,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	26,836,100.00	268,360,100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	600,000.00	600,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	600,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 691 818.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 691 818.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 691 818.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1 691 818.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 691 818.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1 691 818.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	360 000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	360 000.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч Б.Барсболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдүүлэл, орлогыг данс бүртгэлд үнэн зөв тусгах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 20-наас 2021 оны 02 дугаар сарын 07-ны хооронд Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны Ховд аймаг дахь салбарын захирал аудитор Д.Хишгээ хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Жаргалант сумын 6 дугаар сургууль нь “Эрүүл аюулгүй орчинд сурагчдын хичээлийн агуулгын хоцрогдлыг арилгаж сурлагын чанарт ахиц гаргах” зорилгыг дэвшүүлэн дараах зорилтуудыг хэрэгжүүлжээ. Үүнд:

- Танхимын сургалт удаан хугацаагаар зогссоны улмаас хүүхдийн дунд үүсэж болзошгүй айдас түгшүүр, хөгжлийн ялгаатай байдал, сурлагаар хоцрох, сургууль завсардах зэрэг эрсдэлээс сэргийлэх хариу арга хэмжээ авч, тэгш бус байдлыг

бууруулах ажлыг хэрэгжүүлэн, бага боловсролд 6-н настай хүүхдийг бүрэн хамруулж, хамран сургалтыг 0.3 хувиар ахиулах

- Олон нийтийн оролцоот сургууль – Хүний хөгжлийн төв” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж сургуулийн үйл ажиллагаа, хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжихэд эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлийг өргөжүүлэх;
- Сургууль бүр үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээг хамтын оролцоотой хийж, үр дүнд суурилан менежмент, үйл ажиллагаагаа сайжруулах ;
- “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих, тэдний мэдээлэл харилцаа, холбооны технологийн ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг тэргүүлэх чиглэлээ болгож, хүний нөөцийг чадавхжуулах, заах аргын нэгдэл, сонирхлын бүлгээр хамтран цахим хичээл, хэрэглэгдэхүүн бэлтгэж, туршин сайжруулж, багш ээлжит хичээлийн бэлтгэлийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлтгэж, үр дүнтэй хэрэгжүүлэх;
- Багшид үзүүлэх мэргэжил арга зүйн дэмжлэг, туслалцааг суралцагч асуудалд бүтээлчээр хандах, учир шалтгааныг эрэлхийлэх, дүн шинжилгээ хийх, шинэ санаа, шийдэл гаргах, асуудал шийдвэрлэх зэрэг суралцах идэвхтэй үйлийг дэмжсэн арга зүйг хөгжүүлэхэд чиглүүлэх
- Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилттай бэлтгэж, сургуулийн дундаж оноог ахиулах, Чанарын үнэлгээний шалгалтад 4,6,9,12 дугаар ангиудыг амжилттай бэлтгэн оруулах
- Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн суралцагчдад мэргэжлээ зөв сонгох, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх
- Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, сургалтыг танхимын ба танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл, оролцоог дэмжин тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулах
- “Чадварлаг багш”, “Авьяс”, “Номын гэгээ” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн, сурагчдын эх хэлээрээ уншиж ойлгодог, утга төгөлдөр ярьж бичдэг, зохион найруулах, өөрийгөө илэрхийлэх чадварыг сайжруулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 382-р тогтоолоор төрийн албан хаагчдад нэмэгдэл олгох журмын холбогдох хавсралтууд

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

2020 онд Ховд аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж нийт 3,496.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 3,429.1 мянган төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт бичигдсэн байна.

Төлбөрийн актыг хариуцсан эздээр төлүүлэн хэрэгжилтийг ханган ажилласан боловч өмнөх оноос төлөгдөөгүй актын төлбөр 687.4 мянган төгрөгийг байгууллагын төсвийн шуудан холбооны зардлаас аймгийн төсөвт төлж актыг барагдуулсан байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд БАГА гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны нийт орлого тайлангийн 1604148.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 16041.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөн нийт орлогын 2 хувиар тооцлоо.

Алдааны дүн материаллаг бус /эрсдэл бага / үр нөлөөгүй цар тахлын үед ажилчдаа олгосон унаа, хоол, түлшний урамшуулалд нь олон хүнийг хамруулан олгосон материаллаг бус алдаа гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 155,460.14 мянган төгрөгөөр буюу 7.6% хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	
			Дүн	Хувь
Б	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө				
Авлага	219.98	13.66	- 206.32	-93.8%
Бараа материал	91,833.85	162,792.39	70,958.54	77.3%
Үндсэн хөрөнгө	1,954,769.86	2,039,477.78	84,707.92	4.3%
Нийт хөрөнгө	2,046,823.70	2,202,283.83	155,460.14	7.6%
Өр төлбөр	-	41.86	41.86	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,046,823.70	2,202,241.97	155,418.28	7.6%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,046,823.70	2,202,283.83	155,460.14	7.6%

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй

Авлага данс нь 2020 оны эцсийн үлдэгдэл 13.6 мянган төгрөг бөгөөд өмнөх оноос тайлант онд 206.3 мянган төгрөгийн авлага барагдсан байна. Авлагын үлдэгдэлд цалингийн илүү олголтын 12,3, ХХОАТ-ын 1.3 мянган төгрөгийн илүү төлсөнтэй холбоотой авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 162,792.3 мянган төгрөг болж өмнөх оноос 70,958.5 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны үлдэгдэл болон энэ оны худалдан авсан болон хандиваар авсан бараа материал, хөрөнгөө зарцуулаагүй байгаагаас шалтгаалжээ.

Бараа материал данс оны эхэнд 91833.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байснаас тайлант онд 162792.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 13709.9 мянган төгрөгийн бараа

материал зарцуулж оны эцэст 162792.4 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үүнд: Эм боох материал 4315.3, бичиг хэрэг 2032.3, аж ахуйн материал 2741.3, бусад хангамжийн материал 153703.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Эм боох материалын үлдэгдэл 4,315.0 мянган төгрөгийн үлдэгдэл нь Жаргалант сумын Засаг даргын 2020-03-20-ны № 1/288 тоот албан бичиг/Жаргалант сумын ЕБС, СӨБ-ыг гамшгаас хамгаалах аюулгүй байдлын нөөцийн жишиг жагсаалт/, 2020-03-13-ны өдрийн Жаргалант сумын онцгой комиссын хурлын шийдвэр № 05 шийдвэрээр эм боох материалын зардал дээр нөөц бэлтгэсэнтэй холбоотой байна.

Бичиг хэрэг дансны үлдэгдэл 2032.3 мянган төгрөгийн үлдэгдэлд ихэнхдээ үзүүлэн самбарууд болон үйл ажиллагаанд ашигладаг материалууд байна.

Аж ахуйн материал дансны үлдэгдэлд 2741,3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд энэ дансанд тоолуур, гүйдлийн трансформатор, оо вакуум хаалтууд зэрэг материалууд үлдэгдэлтэй байна.

Бусад хангамжийн материалын үлдэгдэл 153703,5 мянган төгрөгийн үлдэгдэлд түрээсийн ном сурах бичиг, 2020 онд Боловсролын яамнаас Физик, Хими кабинетад хандиваар 50173,5 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн зэрэг материалуудыг бүртгэжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,517,877.9 мянган төгрөг болж өмнөх оноос 84,707.92 мянган төгрөгөөр өссөн байна.

Барилга байгууламж дансны үлдэгдэл 1722942.0 мянган төгрөг байгаа бөгөөд оны эхэнд 1598146.9 мянган төгрөг байснаа тайлант онд Жаргалант сумын ОНХСангийн хөрөнгөөр гадна хашаа, хайс,биеийн тамирын дотно, гадна талбайн засварыг “Золдайчин”ХХК-иар 99795.2 мянган төгрөгөөр, 2019 онд 15000.0 мянган төгрөгөөр “Олны хүч” иргэдийн бүлгэм, 2020 онд 10000,0 мянган төгрөгөөр” Буянт тэгш үйлс”ХХК-иар тус тус сургуулийн гаднах авто зогсоолыг гүйцэтгүүлэн улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

Машин тоног төхөөрөмж дансны эцсийн үлдэгдэл 252597.8 мянган төгрөг болж өмнөх оноос 21733,8 мянган төгрөгөөр өссөн нь Боловсрол шинжлэх ухааны яамнаас хөрөнгө оруулалтаар 11984,8, Мобиком 1700,0, Мандах наран 5929,0 төсвийн хөрөнгөөр 2,120.0 мянган төгрөгөөр документ камер, принтер худалдан авч хариуцсан багш ажилчдад нь үндсэн хөрөнгө хүлээн авах шилжүүлэх баримтаар хүлээлгэн өгсөн байна.

Тавилга дансны эцсийн үлдэгдэл 164703.2 мянган төгрөг болж өмнөх оноос 43741.0 мянган төгрөгөөр өссөн нь Аймгийн Засаг даргын тамгын газраас хөрөнгө оруулалтаар сурагчдын ширээ сандал 26718,9, ДЗОУБ –аас 7060,5, Боловсрол шинжлэх ухааны яамнаас 8205,6, төсвийн хөрөнгөөр 1,756.0 мянган төгрөгийн сандал, ширээг багш нарт карт хөтлөн хүлээлгэн өгсөн байна.

Номын фонд данс оны эцэст 71002,9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд өмнөх оноос 6695,5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 831.5 мянга, Боловсрол шинжлэх ухааны яамнаас 6064,0 мянган төгрөгийн түрээсийн сурах бичиг, 40 хувийн хямдралтай /нэн ядуу хүүхдүүдэд олгодог/ сурах бичиг хүлээн авсан нь номын санч хүлээн авсан байна.

Боловсрол шинжлэх ухааны яамнаас ирсэн түрээсийн сурах бичиг 1514.9, 40 хувийн хямдралтай сурах бичиг 781.1, сурах бичиг 3767.9 бүгд 6064,0 мянган төгрөгийн сурах бичгийг сургуулийн номын сан хүлээн авсан байна.

Намар сургуулийн номын санч номоо хүлээн авахад сурах бичгүүд хэвлэлтийн компанийн үнээр хүлээн авсан бөгөөд жилийн эцэст үнэ өөрчлөгдөж сурах бичгүүдийн үнэ

дээр БШУЯ-наас 10 хувь нэмсэн үнийн зөрүү гарч 1314.9 мянган төгрөгний зөрүүг аудитын явцад залруулга хийгдсэн болно.

Үндсэн хөрөнгийн **данс нь** хөрөнгө оруулалтаар 124,795.2 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 4,707,5 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 66,148.0 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн, акталсан хөрөнгө байхгүй. Биет бус хөрөнгө өссөн буурсан үзүүлэлт байхгүй.

Өр төлбөр дансны үлдэгдэл 41,9 мянган төгрөг болж өссөн нь НДШ дутуу төлснөөс шалтгаалжээ. Энэ нь тооцооллын алдаатай холбогдон гарсан.

Урт хугацаат өр төлбөр байхгүй. Бусад өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл мянган төгрөг болж 155,418.3 мянган төгрөгөөр өссөн тайлант онд бий болсон өсөлтөөс шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 411589,2 мянган төгрөгөөр буюу 24,3 хувиар өссөн байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү дүн	Зөрүү хувь
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,691,491.26	2,103,080.43	411,589.18	24.33%

Өмнөх оны үзүүлэлтээс нийт орлого материаллаг өөрчлөлт гарсан нь тусгай зориулалтын болон орон нутгийн санхүүгийн дэмжлэг нэмэгдсэнтэй холбоотой байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү дүн	Зөрүү хувь
УРСГАЛ ЗАРДАЛ	1,649,349.87	1,947,662.16	298,312.29	18.09%

Нийт зардал өмнөх оноос 298,312.4 мянган төгрөгөөр буюу 18.09 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан НДШ –ийн төлөвлөлтийн илүү тооцсон зөрүү, Ковид 19- тэй холбоотой үдийн цай, гэрэл цахилгаан, халаалтын зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл, ажилчдын унаа хоолны нэмэгдэл зардал шинээр гарсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй .

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,914,710.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,914,710.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд 2020 онд хасах тодотгол хийж 54156.0 мянган төгрөгөөр бууруулж 1860554.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Анх батлагдсан төсвөөс 54,156,0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг хасаж тодотгол хийсэн, зарцуулаагүй буцаан төвлөрүүлсэн 44,433.6 мянган төгрөг бүгд 98,589.6 мянган төгрөг зарцуулаагүй нь Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас шалтгаалан байгууллагын үйл ажиллагаа тасалдсантай холбоотой .

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1860554.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 1591594,4 мянган төгрөгийг тусгай зориулалтын төсвөөс, 268360,1 орон нутгийн төсвөөс ,600.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

	Төсвийн хэлбэлзлийн тайлан	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ТГТ, ТХТ -ийн зөрүү
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1 860 554.5	1 816 120.8	44 433.7
Тусламж санхүүжилтийн орлого	1 859 954.5	1 815 520.8	44 433.7
Урсгал төсвөс	1 859 954.5	1 815 520.8	44 433.7
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 591 594.4	1 562 864.6	28 729.8
Орон нутгийн санхүүжилт	268 360.1	252 656.2	15 703.9
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого	600.0	600.0	-
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1 860 554.5	1 816 120.8	44 433.7
Урсгал зардал	1 860 554.5	1 816 120.8	44 433.7
Бараа ажил үйлчилгээний зардал	1 817 549.8	1 787 673.6	29 876.2
Цалин хөлс ба нэмэгдэл урамшуулал, НДШ	1 524 786.4	1 511 132.7	13 653.7
Байр ашиглалттай холбоотой зардал	264 633.2	248 929.3	15 703.9
Хангамж, бараа материалын зардал	4 972.9	4 953.4	19.5
Нормативт зардал	9 952.7	9 915.0	37.7
Эд хогшил, урсгал засварын зардал	3 726.9	3 726.9	-
Томилолт зочны зардал	614.0	160.0	454.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	767.0	767.0	-
Бараа үйлчилгээний бусад зардал	8 096.7	8 089.3	7.4
Урсгал шилжүүлэг	43 004.7	28 447.2	14 557.5
Бусад урсгал шилжүүлэг	43 004.7	28 447.2	14 557.5

Гүйцэтгэлээр улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 1562864.6, орон нутгийн санхүүгийн дэмжлэгээр 252656.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 600.0 мянган төгрөг нийт 1816120,8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1816120,8 мянган төгрөгийг зарцуулж 44433,7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1816120.8 мянган төгрөг буюу 96,8 хувьтай байгаа нь цалин хөлс ба нэмэгдэл урамшуулал НДШ 13653.7, байр ашиглалттай холбоотой зардал 15703.9, хангамжийн зардал 19.5, нормативт зардал 37.7, томилолт 454.0, эздийн цай 14557.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр техник хэрэгсэл авахаар Улаанбаатар хот явах автобус, хоол унааны зардалд 360.0, Сургуулийн заалны болон гуанзны түрээс 1531.8 бүгд 1891.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Энэ орлого 200.0 мянган төгрөгийн орлогыг үндсэн дансны орлогод тайлагнаж үлдэх 1691.8 мянган төгрөгийн орлогыг нэмэлт дансны тайланд тайлагнасан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийг оруулбал зохих 158 мэдээллээс хугацаандаа оруулсан 158 мэдээлэл, хугацаа болоогүй 0 байхгүй мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 2 шилэн дансны мэдээллийг 1-сараас 12 сар хүртэл сар бүр

хугацаандаа шивж илгээж байсан. Жаргалант сумын санхүү албанаас сар бүр шилэн дансныхаа үнэлгээгээ авдаг 1 сараас 12 сарын байдлаар шилэн дансны үнэлгээ 100 % ийн гүйцэтгэлтэй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар: Шим Ус ХХК-д оны эцэст өгөх өглөг тайлагнаагүй 2236.9 , Сахилгын шийтгэл оногдуулсан 139.9 мянган төгрөгийг зардалд бичсэн , зориулалт бусаар 500.0 мянган төгрөгийг шагналд олгосон бүгд 2876.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгөгдсөнийг 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 36340.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3466.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 32874.4 мянган төгрөгийн материаллаг бус алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

Үүнд: Намар сургуулийн номын санч номоо хүлээн авахад сурах бичгүүд хэвлэлтийн компанийн үнээр хүлээн авсан бөгөөд жилийн эцэст үнэ өөрчлөгдөж сурах бичгүүдийн үнэ дээр БШУЯ-наас 10 хувь нэмсэн үнийн зөрүү гарч 1314.9 мянган төгрөгийн зөрүү, Төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт дансны 1691,8 мянган төгрөгийн орлого , зарлага тайлагнасан, Орлого үр дүнгийн тайланд 459,6 мянган төгрөгний орлого дутуу тайлагнасан бүгд 3466,3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил: байхгүй

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 32874,4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах асуудлыг нэгтгэн хянаж үзэх шаардлагатай байна. Үүнд.

- 2020-09-03-ны өдрийн А/483 тоот Ховд аймгийн Засаг даргын захирамжаар Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн анги танхим байрны дотоод орчны агаарын чанарыг сайжруулан дэвшилтэт технологи болох “Окфил” агаар шүүгчийг 158765.0 мянган төгрөгөөр суулгах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн байна. “Окфил” агаар шүүгчийг тус сургууль 1130 ширхэгийг 47 ангид 15255,0 мянган төгрөгөөр “Окфил Эко” ХХК-ны захирал Б.Баасанхүү, Жаргалант сумын 3-дугаар сургуулийн захирал Б.Барсболд нар бараа нийлүүлэх гэрээ байгуулан хийж гүйцэтгэж цонхны агаар шүүгчийг бараа материалын дансанд орлого авсан байна.
- Оны эцэст Коронавируст халдвар ковид-19 цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой

өмнөх оноос өссөн цалингийн өсөлтийн 21.7 хувь буюу 30765.0 мянган төгрөгийг унаа, хоол, түлшний хөнгөлөлтөд олгосон байна.

- 2020 оны 02 сарын 18-ны Ховд аймгийн Засаг даргын А/107 тоот захирамжаар “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөрөнгө гаргах тухай захирамжаар сургуулийн үдийн цай хөтөлбөрийн хэмнэлтээс 800.0 мянган төгрөгийг 2020-оны 02-сарын 20-ны өдөр Буянт үйлийн шим ХХК-д шилжүүлсэн
- БСУГ-аас хөрөнгө оруулалтаар Dell latitude 3400 CTO Business model 2 ширхэг нөтөбүүгийг нэг бүрийг 1793176 төгрөгөөр 3586352 төгрөгөөр бэлтгэсэн зэрэг асуудлуудыг аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангаар авч үзэх шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. АНХАН ШАТНЫ БАРИМТЫН БҮРДҮҮЛЭЛТ:

1.1. Илрүүлэлт:

Бараа материалын худалдан авалт хийхдээ цахим баримт аваагүй, цалингийн тооцооны хуудас дээр ажилчдын гарын үсэг зуруулаагүй, хуулгын дарааллын дагуу баримтаа архивлаагүй, Бараа материалын худалдан авалтын төлбөр хийхдээ нэхэмжлэх зарлагын баримтыг дахин хавсаргаагүй, Голомт банкаар хийгдсэн цалин хөлсний төлбөрийн баримт дутуу байгаа нь Иж бүрэн, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ-ийн тухай хууль зөрчсөн байна.

1.2. Эрсдэл: Тайлан буруу илэрхийлэгдэх, залилан гарах, мэдээллийн үнэн зөв байдал алдагдах

1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч байна.

2. УРЬДЧИЛАН ОРСОН ОРЛОГО

2.1. Илрүүлэлт: Заалны түрээсийн урьдчилан орж ирсэн орлогыг өр төлбөрийн дансанд бүртгээгүй, орлого гэж хүлээн зөвшөөрч бүртгэсэн, заалны орлогод тавих хяналт сул байна. Иж бүрэн, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС-, Сангийн сайдын 388 тоот дансны заавар зөрчсөн байна.

2.2. Эрсдэл: Бүртгэлийн стандарт зөрчих, тайлан буруу илэрхийлэгдэх

2.3. Өгсөн зөвлөмж: Заалны орлогод тавих хяналтыг сайжруулж нягтлан бодох бүртгэлээ үнэн зөв хөтлөн УСНББОУС-, Сангийн сайдын 388 тоот дансны зааврыг мөрдөж ажиллах

1.5. 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч байна.

2. ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ:

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны өмнөх жилүүдийн хувь хүнтэй холбоотой актыг төсвөөс төлсөн, Коронавируст халдвар ковид-19 цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой өмнөх оноос өссөн цалингийн өсөлтийн 22.7 хувь 30765.0 мянган төгрөгийг унаа, хоол, түлшний

хөнгөлөлтөд олгосон байна. Иж бүрэн, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль зөрчсөн байна.

3.2. Эрсдэл: Тайлан буруу илэрхийлэгдэх, залилан үүсэх

3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг баримтлан ажиллах

2.1. 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020	Аудитын нэр: Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/07/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Жаргалант сумын 6 дугаар сургууль	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бараа материалын худалдан авалт хийхдээ цахим баримт аваагүй, цалингийн тооцооны хуудас дээр ажилчдын гарын үсэг зуруулаагүй, хуулгын дарааллын дагуу баримтаа архивлаагүй, Бараа материалын худалдан авалтын төлбөр хийхдээ нэхэмжлэх зарлагын баримтыг дахин хавсаргаагүй, Голомт банкаар хийгдсэн цалин хөлсний төлбөрийн баримт дутуу		Зөвлөмж	Захирал	Б.Барсболд
2	Ном сурах бичгийн үнийн зөрүүтэй бүртгэсэн	1314.9	Залруулга	Захирал	Б.Барсболд
3	Төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт дансны 1691,8 мянган төгрөгийн орлого, зарлага тайлагнасан	1691.8	Залруулга	Захирал	Б.Барсболд
4	Орлого үр дүнгийн тайланд 459,6 мянган төгрөгийн орлого дутуу тайлагнасан	459.6	Залруулга	Захирал	Б.Барсболд
5	Заалны түрээсийн урьдчилан орж ирсэн орлогыг өр төлбөрийн дансанд бүртгээгүй, орлого гэж хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1425.0	Зөвлөмж	Захирал	Б.Барсболд
6	Өмнөх жилүүдийн актыг төсвөөс төлсөн	684.4	Зөвлөмж	Захирал	Б.Барсболд
	Коронавируст халдвар ковид-19 цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан төсөвт зардал	30765.0	Зөвлөмж	Захирал	Б.Барсболд

